



ГТӨВ АЙМГИЙН ЦАГДААГИЙН ГАЗРЫН
ДАРГА А.БАТБАЯР ТАНАА

**ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН
ХАРЬЯА ТӨВ АЙМГИЙН АУДИТЫН
ГАЗАР**

41000 Зуунмод, Төв аймаг
Утас: 70272248, Факс: 70272582, e-mail: tuv@audit.gov.mn

2015.02.25. № ТӨВ-2015/Р1/СТА-ТЦЗ
танай _____-ны № _____-т
Г _____ Г

Аудитын гэрчилгээ

Төсвийн захирагчийн төсвийн 2014 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх дуусвар болсон, аккрузал сууриар бэлтгэгдсэн, жилийн эцсийн санхүүгийн тайланд Төрийн аудитын тухай хуулийн 15.1.1-д заасан бүрэн эрхийн дагуу Төв аймгийн аудитын газраас аудит хийв.

Төсвийн захирагч нь тайлант хугацааны санхүүгийн тайланг холбогдох хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу үнэн зөв бэлтгэж, тайлагнах үүрэг, хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллага нь Төсвийн захирагчийн 2014 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, санал дүгнэлт өгөх үүрэг, хариуцлага хүлээнэ.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журмын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр стандарт, журам нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Төсвийн захирагчийн 2014 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэлийн хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем, гол хууль тогтоомжуудын мөрдөлтийг болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан материаллаг алдаагүй эсэхэд санал дүгнэлт өгөх хангалттай бөгөөд зохистой үндэслэлийг бүрдүүлсэн.

Зөрчилгүй санал дүгнэлт

Төсвийн захирагчийн төсвийн 2014 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлан, илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүд холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн байна.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Л.ЖАРГАЛСАЙХАН

**ТӨВ АЙМГИЙН
ЦАГДААГИЙН ГАЗАР**



**2014 ОНЫ САНХҮҮГИЙН
ТАЙЛАН**

Менежментийн захидал

Тэргүүлэх ач холбогдол №2 зүйлс

Асуудал 1

Төсвийн гүйцэтгэлийн талаар 2

Асуудал 2

НББ-ийн талаар 3

Менежментийн захидал

Төв аймгийн аудитын газар нь аудитын явцад илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг Төсвийн шууд захирагчид зориулж бэлтгэсэн бөгөөд түүнд хяналтын сул тал, горимыг өөрчлөх замаар хяналтыг сайжруулах зөвлөмжийг өглөө.

Энэхүү менежментийн захидлын агуулга АОУС-ын дагуу хийгддэг ТАБ-ын аудитын горимоос урган гарсан болно. Бидний хэрэгжүүлсэн горим, сорил нь санхүүгийн тайлангийн санал дүгнэлт гаргахад зориулагдсан.

Тиймээс аудитын зөвлөмж нь дахин хяналт хийх үеийн нөхцөл байдлын талаархи бидний үнэлэлт, дүгнэлтийг тусгаж байгаа болно.

Төрийн аудитын байгууллага энэхүү зөвлөмжийг та бүхний бүртгэл, тайлагнал, хяналтын үйл ажиллагааг сайжруулах зорилготой бөгөөд харин зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан Төсвийн захирагчийн холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан санхүүгийн ажилтнуудад талархал илэрхийлье.

Асуудал 1 Төсвийн гүйцэтгэлийн талаар

Тэргүүлэх ач
холбогдол

АГ-ын ажиглалт

Бараа материалын тайлангийн журналаас зөв ангилан бүртгэсэн эсэхийг шалгахад хангамжийн материалд тусгай зориулалтын бараа материалыг бүртгэсэн байна.

АГ-ын зөвлөмжүүд

Цагдаагийн ерөнхий газрын 2013 оны 422 тоот тушаалаар батлагдсан нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бигийг мөрдөж ажиллах.


Эрсдэлүүд

Бараа материалын үлдэгдэл буруу тодорхойлогдох.

Үйлчлүүлэгчийн хариу

2015 оны 3 дугаар сарын 01-ний дотор зөвлөмжийг биелүүлэх талаар арга хэмжээ авч ажиллана.

Цагдаагийн газрын
дарга  А.Батбаяр

Нягтлан бодогч  Н.Дашдаваа



АГ-ын ажиглалт

Аймгийн ИТХ-ын тэргүүлэгчдийн 2014 оны 50-р тогтоолоор данс бүртгэлээс хасах шийдвэр нь гарсан 10080.0 мянган төгрөгийн гражийг данс бүртгэлээс хасагдаагүй гарсан шийдвэрийг хэрэгжүүлээгүй байна.

АГ-ын зөвлөмжүүд

Аймгийн ИТХ-ын шийдвэрийг бүрэн хэрэгжүүлэх актлагдсан хөрөнгийг данс бүртгэлээс хасах.


Эрсдэлүүд

УСНББОУС-ын дагуу бүртгэлийг хөтлөөгүйгээс үндсэн хөрөнгийг зөрүүтэй тайлагнах, санхүүгийн тайлан буруу гарах.

Үйлчлүүлэгчийн хариу

2015 оны 5 дугаар сарын 01-ний дотор зөвлөмжийг биелүүлэх талаар арга хэмжээ авч ажиллана.

Цагдаагийн газрын
дарга



А.Батбаяр

Нягтлан бодогч



Н.Дашдаваа

МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДЛЫГ ХЯНАСАН:

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР:

Л.Жаргалсайхан

АУДИТЫН МЕНЕЖЕР:

О.Амаржаргал

БЭЛТГЭСЭН:

АУДИТОР:

Г.Бадар-Ууган

